

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2007 оны 5 дугаар сарын
24-ний өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Зарим тогтоолыг хүчингүй
болсонд тооцох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Санхүүгийн зохицуулах хорооноос тухайн харилцааг зохицуулсан эрх зүйн акт нэгэнт батлагдсантай холбогдуулж Үнэт цаасны Хорооны /хуучнаар/ дараах тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцож цаашид мөрдөхгүй байхаар тогтсугай:

1. 1996 оны “Журмын зарим заалтыг өөрчлөн найруулах тухай” 15 дугаар тогтоол,
2. 1996 оны “Зарим журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 73 дугаар тогтоол,
3. 1996 оны “Зарим журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол,
4. 1996 оны “Журмын заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, зарим журмын заалт, хэсгийг хүчингүй болгох тухай” 297 дугаар тогтоол,
5. 1999 оны “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 69 дүгээр тогтоол,
6. 1999 оны “Зарим журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 07 дугаар тогтоол,
7. 2001 оны “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх тухай журамд нэмэлт оруулах тухай” 20 дугаар тогтоол,
8. 1995 оны “Үнэт цаасны зах зээл” сургалтад хамрагдсан хүмүүст сертификат олгох журам батлах тухай” 23 дугаар тогтоол;
9. 1996 оны “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай журам батлах тухай” 91 дүгээр тогтоол;
10. 1996 оны “МУ-ын ҮЦХ-оос шагнал урамшил олгох тухай журам батлах тухай” 93 дугаар тогтоол, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 1997 оны 68 дугаар тогтоол;
11. 2001 оны “Журам, заавар батлах тухай” 08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол улсын Үнэт цаасны хорооны хуралдааны дэгийн тухай журам”, 2 дугаар хавсралтаар баталсан “Хорооны хуралдааны явцын гар бичмэл, архивт хадгалах, ашиглах журам”, 3 дугаар хавсралтаар баталсан “Үнэт цаасны хорооны тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг хадгалах, ашиглах заавар”;
12. 2003 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны хорооны дүрэм”;
13. 2003 оны 46 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны хорооны ажилтны ёс зүйн хэм хэмжээний дүрэм”;
14. 1996 оны “Журам тогтоох тухай” 46 дугаар тогтоол.

Хоёр. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд сурталчилж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН